

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
яам, Мал аж ахуйн эдийн засгийн
эргэлтийг нэмэгдүүлэх төсөл (6508 MN)
“Залуу мэргэжилтэн хөтөлбөр”

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Дэлхийн банкны санхүүжилттэй, Монгол Улсын засгийн газрын ХХААХҮЯ-ны хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн “Залуу мэргэжилтэн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нь

Хэрэгжүүлэгч байгууллагын нэр: Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл

Хүлээн авагч байгууллагын нэр:

Нийслэлийн Мал эмнэлгийн газар

Нэгжийн нэр:

Мал эмнэлгийн лаборатори

Ажлын байрны нэр:

Хүнсний эрүүл ахуй, үлдэгдлийн шинжилгээ хариуцсан дадлагажигч ажилтан

Ажлын байрны чиглэл:

Оношлогоо, шинжилгээ

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг
(8:30-17:30) цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

БГД, 2-р хороо

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Байгууллагын нууцыг хадгалах, шаардлагатай үед хөдөө орон нутагт албан томилолтоор ажиллах

II.АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Ажлын байрны зорилго:

Хууль тогтоомж, лабораторийн биоаюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд мөрдөж, хүлээн авсан дээжинд батлагдсан стандарт, арга зүйн дагуу тогтоосон хугацаанд эмийн үлдэгдлийн болон хүнсний нян судлалын шинжилгээ хийж оношлох, баталгаажуулах, дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах, сүлжээ лабораторийн эмч нарт зөвлөгөө өгөх, сурган дадлагажуулах, оношлогоо шинжилгээний бэлэн байдлыг хангах чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх бүрэн чадвар эзэмшсэн байна.

Ажлын байрны зорилт:

- 1.Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний болон олон улсын хууль эрхийн акт, дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт, биоаюулгүй ажиллагааны дэг, зөвлөмж арга зүйг баримтлах.
- 2.Дээж, материалд батлагдсан стандарт арга зүйн дагуу шинжилгээ хийж үр дүнгийн үнэн зөвийг хариуцах.
- 3.Өөрийгөө хөгжүүлэх, хариуцсан ажил, тэдгээртэй холбоотой бусад чиглэлээр мэргэших.
- 4.Холбогдох эмч нарыг оношлогоо, шинжилгээний арга аргачлалаар хангах, зөвлөгөө өгөх, гэрээт ажлуудыг чанартай гүйцэтгэх, тайлагнах.
5. Төслийн тасралтгүй үйл ажиллагаа ,сургалт хөтөлбөр, тайлагналтад дэмжлэг үзүүлэн оролцоотой байж идэвх санаачлагатай ажиллах.
- 6.Дотоод үйл ажиллагааны хүрээнд дүрэм журам дагаж мөрдөх, зохих хууль тогтоомж шийдвэрийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэл бусад тайланг цаг тухайд нь тайлагнах,мэдээллийн санг бүртгэлжүүлэн явах.

Зорилт	Дадлагажин гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Лабораторийн биоаюулгүй ажиллагааны дэг, хөдөлмөр, халдвар хамгаалалын журам мөрдөх, гарч болзошгүй халдвар осол, бэртэл, эрсдэлээс сэргийлэх, ажлын үед хувийн хамгаалах хэрэгслийг тогтмол өмсөж ажиллах.	Лабораторийн биоаюулгүй ажиллагааны дэг болон хөдөлмөр, халдвар хамгааллын журмыг мөрдсөн байна.	Г

2 дугаар зорилтын хүрээнд	1.Ирсэн дээжийг тухай бүрд цаг алдалгүй хүлээн авах ба дээж шинжилгээнд тэнцэх эсэхийг шалгах, тодруулга хийх, холбогдох шаардлага, заалтад нийцэхгүй бол буцаах,		Г,Т
	2.Дээжийг бүртгэлийн дугаарын дагуу хаягжуулж хугацаанд багтааж шинжилгээ хийх, журмын дагуу хадгалах, устгалд оруулах ,		Г,Т
	3.Шинжилгээ хийх арга аргачлалыг стандарт, заавар, техникийн шаардлагад нийцүүлэн нарийн чанд баримтлах ба шинжлэх үзүүлэлтийг бүрэн хийх,		Г
	4.Лабораторид стандарт шаардлагад нийцүүлэн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, ашигласан багаж хэрэгслийг шалгаж ашиглалтын дэвтрийг тогтмол хөтөлж гарын үсэг зурах,		Г,Т
	5.Шинжилгээний үр дүнд гаргасан омог, өсгөвөр, нуклейн хүчил гэх мэт материалыг зориулалтын саванд хийж лацдан, хаяг шошго нааж бүртгэлжүүлэн хөргүүрт хадгална. Шаардлагатай бол дахин сэргээх хугацааг бүртгэлийн тайлбар хэсэгт нарийвчлан заах,	Шинжилгээнд ирсэн дээжийг холбогдох стандарт, арга, аргачлал, дүрэм, журмийн дагуу чанартай, хариуцлагатай, хугацаанд нь гүйцэтгэж, шинжилгээний дүн, дүгнэлтийг гаргах, холбогдох байгууллагад илгээсэн байна	
	6.Оношлуур, цомог, урвалж бодис, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, хийх, тогтмол бүртгэл хөтлөх, захиалга хийх, зарцуулалт, тайлан гаргах,		Т
	7.Албан тушаалд холбогдох бүх бичиг баримт, экспертизийн дэвтэр, шинжилгээний явц, өгөгдөл, тооцоолол, үр дүнг хөтлөх, цахимд хариуг хавсралтын хамт илгээх, баримт бичгийн эхийг хэвлэж, архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хавтаслах, архивд хүлээлгэн өгөх,		Т
	8.Шинжилгээний хариу эерэг гарсан бол удирдлагаас шийдвэр иртэл хариуг гадагш гаргах, бусдад мэдээлэхгүй байх,		Г

	9.Эцсийн онош, дүгнэлтийг харгалзан удирдлага болон дээд шатны байгууллагаас шийдвэр гарсан үед дээжийг зохих журмын дагуу боловсруулан савлаж бэлтгэн, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, лавлагаа лабораторид илгээх асуудлыг чанарын менежерийн хяналт дор гардан гүйцэтгэх, 10.Шуурхай дуудлага, гоц халдварт, нийтийг хамарсан хордлого гэх мэт онцгой нөхцлөөр ирсэн дээжийг цаг алдалгүй шинжлэх.		Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Оношлогдсон өвчин, хордлого, үзүүлэлт болон оношлогоо, баталгаажуулалт, тандалтын дүн, бүртгэл, судалгаа, мэдээлэл гаргах, тайлагнах, 2.Зайлшгүй шаардлагатай орчин үеийн шинэ техник хэрэгсэл, цомог оношлуур, дэвшилтэд арга аргачлал болон өвчин, хордлогын талаар гүнзгийрүүлсэн мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх санаачлага гаргах, шинжилгээнд нэвтрүүлэх, 3.Хариуцсан албан тушаалын хүрээнд төсөл, хөтөлбөрт оролцох, бие даан боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, тайлагнах, хэвлэн нийтлэх.	Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, тандалт, судалгааны ажилд идэвхи санаачлагатай оролцож дүн, дүгнэлт, үр дүнг тайлагнасан байна. Шинжилгээний шинэ арга, аргачлал нэвтрүүлэх, САЗ орчуулж, нутагшуулсан байна.	Г Г Г,Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Өвчин хордлого, оношлогоо шинжилгээний стандарт, заавар, ном, товхимол, зөвлөмж судлах, мэдлэг дээшлүүлэх, 2.Мэргэжлийн түвшинд гадаад хэл судлах, мэдээлэл олох, бичиг баримт боловсруулах, илтгэх, тайлагнах чадвар эзэмших, 3.Оношлогоо, шинжилгээ, хариуцсан лаборатори, албан тушаалтай холбогдох мэдлэг, арга туршлагыг олж авах, хуваалцах, солилцох, шинэ санал, санаачилга гаргах, өөрийн олж авсан мэдлэг туршлагыг бусдад зааж сургах, уламжлуулах, гэрээнд тусгагдсан ажлыг чанартай гүйцэтгэх, 4.Мэргэшил, боловсролын зэрэг, ур чадвар ахиулах,	Тухайн оношлогоо, шинжилгээтэй холбоотой стандарт, арга зүй, орчин үеийн мэдлэг, мэдээллийг олж авч, эзэмших, практикт ашиглах, бусадтай хуваалцах, судалгаа шинжилгээ ажил хийж, үр дүнг тайлагнасан, хэвлэн нийтлүүлсэн байна. Мэргэшил, боловсролын зэрэг, ур чадвараа дээшлүүлсэн байна.	Г Г Г Г

	5.Бие даан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, үр дүнг хэвлэн нийтлүүлэх, олны хүртээл болгох.		Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Бүтээмжит түншлэлийн дэд төслүүдийн гэрээний хэрэгжилтийг төслийн газар дээр болон зайнаас хянахтай холбоотой ажлуудыг, хяналт тавихад хамтран ажиллах аймаг, сумдын хөдөө аж ахуйн газар, алба, нэгжүүдтэй төслийн нэгжийн удирдлагын хүрээнд дэмжлэг үзүүлэх	Дэд төсөл дээр ажиллах	Т ба Г
	2.Төслийн нэгжийн үйл ажиллагаанд дэд төслүүдийн санхүү, эдийн засаг, худалдан авалт, хяналт-шинжилгээтэй холбоотой мэдээлэл цуглуулах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагаанд хамтран ажиллах.Шаардлагатай судалгаа мэдээллийг цуглуулах, мэдээллийн санд оруулах, холбогдох талуудад хүргүүлэх	Хамаарна	Т ба Г
	3.Төслийн нэгжээс зохион байгуулах “Төслийн удирдлага” “Хувь хүний хөгжлийн” модуль, семинар сургалтуудад идэвхтэй оролцох	Хамаарна	Г
	4.Дэд төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахтай холбоотой ажлуудад болон “Залуу мэргэжилтэн” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд идэвхтэй оролцох	Хамаарна	Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Дотоод журмыг чанд мөрдөн ажиллах,удирдлагаас өгсөн үүрэг даалгавар,гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь тайлагнах	Хариуцсан чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тоо, хэмжээ, үр дүн	Т ба Г
	2.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажилласан байна	Т ба Г
	3.Хариуцсан салбарын чиглэлээр статистик тоон мэдээллийг нэгтгэх, танилцуулга бэлтгэн файлын сан үүсгэх	Хариуцсан салбарын чиглэлээр мэдээллийн нэгтгэсэн сан үүсгэсэн байна	Т ба Г

III. АЖЛЫН БАЙРАНД ТУСГАЙ ТАВИГДАХ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр боловсролын зэрэгтэй, 2.5-аас дээш голч оноотой төгссөн байх,	
Мэргэжил	- Мал эмнэлэг /0841/, Хүнс боловсруулалт /0721/, Хими /0531 /	
Мэргэшил	Мэргэшлийн чиглэлээр сургалтанд хамрагдсан бол давуу тал болно	
Туршлага	Мэргэжилээрээ ажилласан бол давуу тал болно	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - хариуцсан ажлын чиглэлээр дүн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах; - бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачлагыг дэмждэг байх; - аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх; - аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Бусад	- олон нийттэй харилцах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэд технологи ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвартай байх.
IV. ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
<u>Шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>		
-		
<u>Бусад харилцах субъект:</u>		
-		
V. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
<u>Ажлын байрны тодорхойлолт боловсруулсан:</u>		<u>Ажлын байрны тодорхойлолтыг танилцаж хүлээн зөвшөөрсөн:</u>

<u>Байгууллагын нэр:</u> Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх <u>Албан тушаал:</u> Төслийн захирал <u>(Гарын үсэг)</u> 2023 оны дугаар сарын-ны өдөр	<u>Залуу мэргэжилтний нэр:</u> <u>(Гарын үсэг)</u> <u>(Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)</u> 2023 оны дугаар сарын-ны өдөр
---	--